

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:НТАГ-2026/045/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Audit.mn</p> <p>Нийслэл дэх Төрийн аудитын газар 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal.g@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ийн захирал: Ж.Баяртуул Утас:99066015, Цахим хаяг: Auditbalance6015@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 026  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР ДЭВШИЛ  
МЕНЕЖМЕНТ ААТҮГ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ГАНХУЯГ  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны нийт орлогыг 7,327.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 8,412.2 сая төгрөгөөр, 6,980.4 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 7,348.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,163.6 сая төгрөгийн зардал гарган 1,184.5 сая алдагдалтай ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сүхбаатар дүүргийн ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдаанаар баталсан “Үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 9/51 дүгээр тогтоолын дагуу гэр хороолол, орон сууцны айл өрхийн хог хураамжийн төлбөрийг нэмэгдүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 95.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон. /төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,059,383,779.70	857,321,882.01
1.1.2	Дансны авлага	11,502,080.00	116,921,512.00
1.1.6	Бараа материал	141,177,268.15	197,624,724.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,400,000.00	5,846,900.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,220,463,127.85	1,177,715,018.70
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,690,743,343.55	3,717,156,460.13
1.2.2	Биет бус хөрөнгө	35,911,643.82	36,347,019.62
1.2.3	Дуусаагүй барилга   Биологийн хөрөнгө	21,105,221.23	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,747,760,208.60	3,753,503,479.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,968,223,336.45	4,931,218,498.45
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	439,600.00	757,332.40
2.1.1.3	Татварын өр	49,097,650.13	88,450,017.56
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	268,529,944.43	23,103,632.83
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	29,550,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	318,067,194.56	141,860,982.79
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.5	Хойшлогдсон орлого	1,201,289,295.88	2,274,440,511.55
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,201,289,295.88	2,274,440,511.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,519,356,490.44	2,416,301,494.34
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Төрийн өмч	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,000,000.00	11,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,437,866,846.01	2,503,917,004.11
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,448,866,846.01	2,514,917,004.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,968,223,336.45	4,931,218,498.45

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан***2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.**/төгрөгөөр/*

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,502,511,417.59	4,978,191,939.67
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	2,502,511,417.59	4,978,191,939.67
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Бусад орлого	1,944,204,875.64	2,369,886,914.76
7	Борлуулалт, маркетингийн зардал	2,787,366,909.10	5,259,858,384.92
8	Ерөнхий ба удирдлагын зардал	451,411,494.53	800,241,416.84
9	Санхүүгийн зардал	-	-
10	Бусад зардал	25,931,044.34	103,478,877.01
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,182,006,845.26	1,184,500,175.66
13	Орлогын татварын зардал	118,200,684.52	118,450,017.56
14	Татварын дараах ашиг (алдагдал)	1,063,806,160.74	1,066,050,158.10
15	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
16	Тайлант үеийн ашиг (алдагдал)	1,063,806,160.74	1,066,050,158.10
17	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
18	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
19	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
20	Бусад олз (гарз)	-	-
21	Орлогын нийт дүн	1,063,806,160.74	1,066,050,158.10
22	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан***2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.**/төгрөгөөр/*

Д/д	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,000,000.00	374,060,685.27	385,060,685.27
2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	1,063,806,160.74	1,063,806,160.74
3	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,000,000.00	1,437,866,846.01	1,448,866,846.01
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	1,066,050,158.10	1,066,050,158.10
5	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,000,000.00	2,503,917,004.11	2,514,917,004.11

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	4,155,141,860.59	6,948,383,220.07
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,535,018,847.59	4,894,027,722.07
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,148,613.00	18,768,102.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,615,974,400.00	2,035,587,396.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	3,090,747,352.28	5,906,038,687.76
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,025,613,886.02	3,725,341,997.97
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	257,208,744.03	473,231,985.81
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	189,300,278.00	597,242,603.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	16,457,420.25	19,697,965.57
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	407,919,126.43	477,978,089.90
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	94,114,743.55	87,921,044.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	17,057,074.00	49,113,886.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	83,076,080.00	475,511,115.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,064,394,508.31	1,042,344,532.31
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	188,734,270.00	1,244,406,430.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	187,084,270.00	1,242,142,270.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,650,000.00	2,264,160.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(188,734,270.00)	(1,244,406,430.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	875,660,238.31	(202,061,897.69)
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	183,723,541.39	1,059,383,779.70
7	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,059,383,779.70	857,321,882.01

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
1	ААН орлого	717,749,414	702,840,000	751,843,500.00	49,003,500	107%
2	ХҮТ / орон сууц/	107,532,680.00	494,968,320	470,605,120.03	(24,363,200)	95%
3	Гэр хороолол	222,297,464	268,038,000	264,324,895.64	(3,713,104)	99%
4	Тохижилт үйлчилгээний орлого	1,358,031,860	3,218,762,554	3,218,762,554.00	-	100%
5	Ногоон байгууламж цэвэрлэгээ арчилгаа		105,530,870	105,530,870.00	-	100%
6	Иргэдийн бүлэг	96,900,000	102,000,000	102,000,000.00	-	100%
7	Татаас санхүүжилт	1,615,974,400	2,035,587,396	2,035,587,396.00	-	100%
8	Бусад орлого	328,230,476	328,714,719	328,714,718.76	-	100%
10	Тохижилт үйлчилгээ,ногоон байгууламж, бүтээн байгуулалтын зардал	-	65,125,000.00	65,125,000.00	-	100%
Нийт дүн		4,446,716,293	7,321,566,859	7,342,494,054	20,927,196	100%
1	Цалин хөлс	1,979,088,440	4,049,776,372	3,611,421,277	438,355,095	89%
2	Нийгмийн даатгалын шимтгэл	256,882,632	538,601,262	473,231,985	65,369,277	88%
3	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	959,051	60,000,000	10,804,450	49,195,550	18%
4	Бичиг хэргийн зардал	7,986,562	14,000,000	8,913,920	5,086,080	64%
5	Ашиглалтын зардал	15,116,320	44,000,000	10,453,542	33,546,458	24%
6	Аж ахуйн материал	56,258,131	60,000,000	19,675,761	40,324,239	33%
7	Хангамж , цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	61,307,123	10,000,000	8,713,349	1,286,651	87%
8	Сургалтын зардал	3,005,000	5,000,000	3,719,000	1,281,000	74%
9	Түрээс. тээвэр зардал /автомашин, тоног төхөөрөмж/	79,075,574	30,000,000	33,735,200	(3,735,200)	112%
10	Тогтмол үйлчилгээ, засварын зардал	32,283,250	38,225,000	16,429,710	21,795,290	43%
11	Шатахуун тос тослох материалын зардал	238,949,361	465,000,000	290,352,247	174,647,753	62%
12	Даатгалын зардал	19,766,825	50,000,000	46,778,494	3,221,506	94%
13	Утас, интернэтийн зардал	2,117,445	5,000,000	1,898,000	3,102,000	38%
14	Томилолтын зардал /унаа, буудал, хоол/	28,500,000	20,000,000	17,600,000	2,400,000	88%
15	Хэвлэлийн зардал	1,424,120	5,000,000	2,200,000	2,800,000	44%
16	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	40,723,300	85,000,000	90,609,005	(5,609,005)	107%
17	Банкны үйлчилгээний зардал	112,400	750,000	109,500	640,500	15%
18	Эм, бэлдмэл, хоргүйжүүлэлд, дархлаажуулалт, эмнэлгийн хэрэгсэл		15,500,000	13,395,600	2,104,400	86%
19	бусад зардал	10,179,305	8,320,000	5,547,151	2,772,849	67%
20	Тохижилт үйлчилгээ,ногоон байгууламж, бүтээн байгуулалтын зардал		366,505,000	382,117,342	(15,612,342)	104%

21	Тусгай зориулалтын давс, бодис	59,270,000	407,300,000	486,125,000	(78,825,000)	119%
22	Элэгдэл,хорогдлын зардал	209,063,826	352,797,959	352,797,959	-	100%
23	Хөдөлмөр хамгааллын зардал	51,776,581	172,628,000	110,487,293	62,140,707	64%
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	43,382,200	55,000,000	46,284,561	8,715,439	84%
25	Сэлбэг хэрэгслийн зардал	65,166,058	75,000,000	98,417,961	(23,417,961)	131%
26	Ахмадын сан		12,149,329	9,000,000	3,149,329	74%
27	Онцгой байдлын зардал	2,315,944	34,877,686	12,760,372	22,117,314	37%
Нийт дүн		3,264,709,448	6,980,430,608	6,163,578,679	816,851,929	88%
1	Татварын өмнөх ашиг/алдагдал	1,182,006,845	341,136,251	1,178,915,375.67		
2	Орлогын албан татвар	118,200,685		117,891,537.57		
3	Цэвэр ашиг/алдагдал	1,063,806,161		1,061,023,838.10		
4	Ногдол ашгийн өглөг					
6	Төсөвт					
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох					
5	Хөрөнгө оруулалт	174,200,000		1,070,600,000		
8	Нийт авлага	19,902,080		116,921,512		
9	Нийт ер төлбөр	49,537,250		53,410,965		
10	Нийт худалдан авалт	180,334,270		1,243,970,680		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,020.5 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

- Элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, анхны үнийн дүнгийн 50 хувиар буюу 5,584.8 мянган төгрөгөөр бүртгэхдээ “хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд бүртгэсэн байна.
- Өөрийн хөрөнгөөр худалдан авсан 435.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хөрөнгөөр бүртгэсэн байна.

НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, MNS-6817-4:2020 стандартын санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг; 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдээгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” заалт, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 38,909.4 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 8,208.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 30,701.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 38,909.4 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

Цалинг давхардуулсан, илүү цагийн хөлсийг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн нийт 8,208.5 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, цалин давхардуулан олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Илрүүлэлт-1:** Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 19,027.9 мянган төгрөгийг урамшуулал болон бичиг хэргийн зардалд зарцуулсан байна. Энэ нь МУЕС-ын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.1-т "Монгол Улсын 2025 оны нээгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг хуваарилан зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар харьяа байгууллагын удирдлагад үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож ажиллах", 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох", 1.4.3-т "тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, хөтөлбөр, арга хэмжээний зардлуудыг хэмнэх, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт-2:** Байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь цалингийн нягтлан бодогчийн үүрэгт ажлыг хавсран гүйцэтгэж 11,008.2 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Албан тушаалын тодорхойлолтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт-3:** Өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй 664.8 мянган төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дээрх алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгөв.

### 3.3 Зөвлөмж

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө орлогоор бүртгэхдээ буруу данс ашигласан.	1	5,584.8			1	5,584.8	1	5,584.8				
Тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хөрөнгөөр бүртгэсэн байна.	1	435.7			1	435.7	1	435.7				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,020.5</b>			<b>2</b>	<b>6,020.5</b>	<b>2</b>	<b>6,020.5</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, урамшууллын зардалд зарцуулсан байна.	1	19,027.9					1	19,027.9				
Ерөнхий нябо цалин хөлсний нябог хавсарсан	1	11,008.2					1	11,008.2				
Өмнөх оны авлагаар тусгаагүй боловч тайлант оны зардлаар тооцсон.	1	664.8					1	664.8				
Цалин, илүү цагийн хөлс тогтоосон	1	8,208.5			1	8,208.5						

хэмжээнээс хэтрүүлэн болгосон												
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>38,909.4</b>			<b>1</b>	<b>8,208.5</b>	<b>3</b>	<b>30,700.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Дүн</b>									
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт									
Байгууллагын бүтэц орон тоонд батлагдаагүй зөвлөх ажиллуулж цалин олгосон байна.	1	17,563.6			1	17,563.6			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>17,563.6</b>			<b>1</b>	<b>17,563.6</b>			-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>17,563.6</b>			<b>1</b>	<b>17,563.6</b>			-